



Нийцлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ,
ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
2022 он



**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/29

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2022 оны А/34 дүгээр тушаалаар батлагдсан “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тайланг хянаж, нийтэд мэдээлэх УВА-2022/19-14-НА-СТА дугаартай нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Татварын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор С.Батсайхан нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200160130

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын нэр:

Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт "Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ" гэж заасныг үндэслэн Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээллээ.

Аудитын зорилго:

Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн бүрдүүлсэн орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, эрх бүхий байгууллагаас гаргасан лавлагаа мэдээлэл, арилжааны банкны ирүүлсэн нэр дэвшигчийн хандивын дансны хуулга, сонгуулийн зардлын тайланд аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт зэрэг шаардлагатай эх сурвалжийг хамруулсан.

Арга зүй:

Аудитын ажлыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Үндсэн мэдээлэл:

Увс аймгийн Баруунтуруун сумын 4-р багийн 1 тойрог, Давст сумын 2-р багийн 1 тойрог, Түргэн сумын 2-р багийн 1 тойрог, Өндөрхангай сумын 5-р багийн 1 тойрогт тус тус явуулах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн өдрийг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр байхаар товлон зарласан байна.

Баруунтуруун, Түргэн, Өндөрхангай сумдын Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нийт 2 намаас 6 нэр дэвшигч оролцсон байна. Үүнд:

/Хүснэгт 1/

Намын нэр	Нам	Нэр дэвшигчид
Монгол ардын нам	1	3
Ардчилсан нам	1	3
Нийт	2	6

Эх сурвалж: /Аймгийн сонгуулийн хороо/

Харин Давст сумын нөхөн сонгуульд нэр дэвшигч бүртгүүлээгүйгээс сонгууль зохион байгуулагдаагүй байна.

Сонгуулийн зардлын дансны орлого, зардал:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу хуулийн хугацаанд 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Нөхөн сонгуульд оролцсон 6 нэр дэвшигчээс 4 нэр дэвшигч данс нээлгээгүй, 2 нэр дэвшигч данс нээлгэсэн боловч орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу Увс аймагт үйл ажиллагаа явуулж буй Хаан банк, Голомт банк, Төрийн банк, Хас банкууд хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад

мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчин нөхөн сонгуульд Монгол Ардын намаас нэр дэвшсэн М.Мэндбаяр, У.Байгалмаа, Ю.Нямсүрэн, Ардчилсан намаас нэр дэвшсэн С.Удаанжаргал, Г.Эрдэнэчимэг, Э.Бямбажав нар сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна.

Аудитын дүгнэлт:

1.Баруунтуруун, Түргэн, Өндөрхангай сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 6 нэр дэвшигчээс 4 нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгээгүй, 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгэсэн боловч орлого, зарлагын гүйлгээ хийгээгүй байна.

2.Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

3.Нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна.

Аудитын зөвлөмж:

Аймгийн Татварын хэлтэст:

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлээгүй нэр дэвшигчдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12-т зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахаар заасны дагуу Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21-д заасан арга хэмжээг авах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР


С.БАТСАЙХАН
Ч.МӨНХТОГТОХ
Б.ЭНХМАНДАЛ

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг
Увс аймаг дахь Төрийн аудитын газарт бүртгүүлээгүй нэр дэвшигчид.

Д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр
1	Баруунтуруун сум	АН	Самбуу УДААНЖАРГАЛ
		МАН	Магалжав МЭНДБАЯР
2	Өндөрхангай сум	АН	Годон ЭРДЭНЭЧИМЭГ
		МАН	Уртнасан БАЙГАЛМАА
3	Түргэн	МАН	Юнгээ НЯМСҮРЭН
		АН	Эрдэнэчулуун БЯМБАЖАВ

Судалгаа гаргасан: Аудитор

Судалгаа хянасан: Ахлах аудитор

Ч.Мөнхтогтох
Б.Энхмандал
С.Батсайхан

